

“Бүрдийн уянга” зусланд амрагчдын эрхийн
бичгийн үнэ өөрчлөх талаарх танилцуулга

Бүрдийн уянга хүүхдийн зуслан нь 2015 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 30 дугаар тогтоолоор 6 хоногийн 85,000 төгрөгийн хураамжийг баталсан бөгөөд одоог хүртэл тус тарифаар үйл ажиллагаагаа явуулж байна. Зусланд хэрэглэгдэх хүнсний бүтээгдэхүүн, бараа, бензин шатахууны жил жилийн үнийн өөрчлөлт, өсөлттэй уялдуулан Зуслангийн үнэ тарифад өөрчлөлт оруулж 6 хоногийн 158,000 төгрөг болгох саналыг танилцуулж байна. Иймд та бүхэн тус саналтай танилцан санал хүсэлтээ илгээнэ үү.

№	Төлбөрийн утга	2015 онд баталсан	2022 онд төлөвлөж буй	Тайлбар
1	Хүүхдийн эрхийн бичгийн үнэ	85,000	158,000	Хөгжүүлэх хөтөлбөр, хоол унааны зардал
2	Насанд хүрэгчдийн эрхийн бичгийн үнэ	20,000	31,000	Өдрийн 3 хоол, хөнгөн цай, тараг
3	Насанд хүрэгчдийн байрны болон үйлчилгээний үнэ	5,000	14,500	Хоолны үйлчилгээ авахгүй, зөвхөн байрлах
4	Сургалт зохион байгуулах байр ашиглуулсны төлбөр	80,000	100,000	Сургалтын тоног төхөөрөмж орохгүй, ширээ, сандал, өрөө, гэрэл цахилгаанаар хангах

“Бүрдийн уянга” зусланд амрагчдад үйлчлэх
хөнгөлөлт, урамшууллын тариф

1. Нэг ангиас 15 болон түүнээс дээш хүүхэд амрахад 1 хүүхэд үнэ төлбөргүй амраана.
2. Нэг ангиас 30 болон түүнээс дээш хүүхэд амрахад 2 хүүхэд болон ангийн багшийг үнэ төлбөргүй амраана.
3. 3 жил дараалан амарсан хүүхдийг 4 дэх жилдээ амрахад 50% хөнгөлөлттэй.
4. 3 болон түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл амрахад 0-3 настай хүүхдийн зардлыг 100% хувь хөнгөлнө.
5. Аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын албан хаагчдын өөрийн хүүхдийг зусланд амрахад байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд шийдвэрлэнэ.

Äóí äã âü àèí æèí Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын
дэргэдэх “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн мэдээлэл

Бүрдийн уянга хүүхдийн зуслан 1983 онд байгуулагдсан, аймгийн төвөөс баруун хойд зүгт 70 км-т Адаацаг сумын нутаг “Сүм хөх бүрд” байгалийн үзэсгэлэнт газарт оршдог орон нутгийн өмчит байгууллага юм.

Бүрдийн уянга зуслан нь тус бүр 50 хүүхэд амрах 4 байр, 25 хүүхэд амрах 1 байр, ажилчдын 8 байр, клуб, эмнэлгийн байр, номын сан, халуун ус угаалгын газар, хүнс барааны склад, гүний худаг, зочид буудал, зоогийн газар, хүүхдийн спортын уралдаан тэмцээн явуулах талбай болон 15600 м² /120м*130м/ хүнсний ногооны талбайтай хүүхдийн зуны амралтаа өнгөрүүлэх томоохон байгууламж юм.

Аймгийн Засаг даргын 1997 оны 201 тоот захирамжаар “Бүрдийн уянга” хүүхдийн зусланд Хүүхдийн төлөө төв /хуучин нэрээр/-тэй нэгтгэсэн.

1983-2012 он хүртэл зуслан нь хүүхдийн зуны амралтыг ая тухтай өнгөрүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, шинэ мэдлэг мэдээллийг олгох, авъяас чадварыг хөгжүүлэх, хүрээлэн буй байгаль орчинтой танилцуулах, амьдрах ухаанд сургах чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирсэн.

1983-2002 онуудад хүүхдийн хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байсан бөгөөд 2003 оноос эхлэн улсын төсвөөс санхүүжилт олгохоо больж, өөрийн орлогоор санхүүжилтийг бүрдүүлэн ажиллаж ирсэн нь зуслан бүрэн хүчин чадлаараа ажиллахад хүндрэл учирсан билээ.

Бүрдийн уянга хүүхдийн зуслан нэг ээлжинд 225 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай.

2005 онд 0° âë° ðñ° í өндөр хүчдэлийн цахилгааны эх үүсвэрт холбогдож, 2012 î í ä óëñüí 0° ñâèéí 200.0 ñàÿ 0° æð° ã èé 0° ð°í Æ î ðóóèèòààð èõ çàñààð òèéããýæ á¿ðýí ò¿÷èí ÷àèèààð àæèèèàð 0àà0àè î ð÷èí í° 00° è á¿ðãñýí .

2021 онд МОБИКОМ-ын сүлжээнд холбогдсон.

УЛААНБААТАР ХОТ БОЛОН БУСАД АЙМГУУДЫН
ЗУСЛАНГУУДЫН ХУРААМЖ (2019 оны байдлаар)

№	Аймаг, нийслэл	Зуслангийн нэр	Амрах хоног	1 өдрийн үнэ (төгрөг)	Нийт төлбөр (төгрөг)
1.	Улаанбаатар	Олон улсын Найрамдал цогцолбор	6-10	25000-54500	49500-327000
2.	Улаанбаатар	Нарлаг зуслан	6	27500	165000
3.	Улаанбаатар	Нарс зуслан	6	27000	162000
4.	Улаанбаатар	Ундраа зуслан	6	26700	160000
5.	Улаанбаатар	Жавхлант зуслан	6	28400	170000
6.	Улаанбаатар	Галакси	6	28400	170000
7.	Улаанбаатар	Хайрын бэлэг	6	25000	150000
8.	Улаанбаатар	Мөрөөдөл	6	33400	200000
9.	Өмнөговь	Буянт хотхон	6	21000	126000
10.	Архангай	Тамир	6	20000	140000
11.	Баянхонгор	Өвгөн жаргалант	6	21000	126000
12.	Баян-Өлгий	Зост Өлгий ХХК	6	25000	175000
13.	Говь-Алтай	Андууд	6	15000	105000
14.	Дархан-Уул	Зулзагын гол	6	15000	105000
15.	Дорнод	Дөлгөөн энх	6	15000	105000
16.	Дундговь	Бүрдийн Уянга	6	12145	85000
17.	Завхан	Дөлгөөн энх	6	20000	140000
18.	Орхон	“Найрамдлын Эрдэнэс”	6	28400	170000
19.	Сэлэнгэ	Гүн нуур	6	20000	140000
20.	Увс	Буянт хотхон	6	18000	126000
21.	Хөвсгөл	Уран дөш	6	18000	126000
Нэг өдрийн дундаж				22247	



